

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ

20 *20* оны *02* дугаар
сарын *06* өдөр

Дугаар ... *128/2020*

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс:

| | |
|--|---|
| Барилга, байгууламжийн байршил, нэр, зориулалт: | Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сум “Эмчийн байр, гарааш, морг, 15 ортой эмнэлгийн барилга”-ын ажлын зураг төсөл, төсөв Шифр: ЦЭ-12-12/19 |
| Хүчин чадал: | <p>“15 ортой сум дундын эмнэлэг” Барилгын хэмжээ: Тэнхлэгээрээ 46.4 м х 16.8 м хэмжээтэй, Давхрын тоо: ± 0.00 түвшнээс доош зoorьгүй, ± 0.00 түвшнээс дээш 2 давхар, S =990.18 м², 15 ортой</p> <p>“Эмчийн байр, 2 машины гарааш” Барилгын хэмжээ: Тэнхлэгээрээ 15.0 м х 8.0 м хэмжээтэй, Давхрын тоо: ± 0.00 түвшнээс доош зoorьгүй, ± 0.00 түвшнээс дээш 1 давхар, S =554.48 м²,</p> <p>“Морг” Барилгын хэмжээ: Тэнхлэгээрээ 9.6 м х 6.0 м хэмжээтэй, Давхрын тоо: ± 0.00 түвшнээс доош зoorьгүй, ± 0.00 түвшнээс дээш 1 давхар, Хүчин чадал: S =50.04 м²</p> |
| Захиалагч: | Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг дарга |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар |
| Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр | “Цэсда” ХХК |
| Регистрийн дугаар: | РД: 2133601 |
| Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа: | 2022.01.06 |
| Ажилбарын төрөл: | 1.2.1, 1.2.4 заалтуудын дагуу |
| Зураг төсөл боловсруулах үндэслэл: | |
| Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо: | Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны 07-р сарын 06-ны өдрийн А/66 дугаар захирамж |
| Зураг төсөл боловсруулах даалгавар: | Баянхонгор аймгийн ерөнхий архитекторын 2019 оны 11-р сарын 20-ны өдөр баталсан 48/2019 БХР тоот архитектур төлөвлөлтийн даалгавар Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг дарга болон “Цэсда” ХХК-ийн захирал нарын хооронд 2018 оны 12-р сарын 06-ны өдөр байгуулсан ЦЭ-12-4/2018 тоот гэрээ |

Техникийн нөхцөл олгогдсон:

| Техникийн нөхцлүүд: | Олгосон байгууллага | Дугаар, огноо | Хүчинтэй байх хугацаа |
|----------------------------------|--------------------------------|-------------------------|-----------------------|
| Цахилгаан хангамж: | "Баянхонгор-Эрчим хүч" ЦТ ХХК | 2018.10.01 2018/79 | - |
| Дулаан хангамж: Усан хангамж: | "Марал гүн" ХХК | 2019.04.15 | - |
| Холбоо, дохиолол: | Баянхонгор аймгийн ТӨХХК "МХС" | 2019.03.27 А 10/2019 | 1 жил |

Зөвшөөрөлцсөн байгууллагууд:

| | |
|--|---------------|
| Баянхонгор аймгийн ерөнхий архитектор | С.Хүрэлхуяг |
| Баянхонгор аймгийн ГХБХБГазрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Цэцэнбилэг |
| Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын дарга, Хурандаа | А.Алтанбагана |
| Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга | Н.Бямбадорж |

Зураг төслийн бүрэлдэхүүн:

| | | |
|-------------------------------------|---|--------------------------|
| Зургийн бүрдэл: | Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр: | Шалгасан экспертийн нэр: |
| Барилга архитектур, ЕТ: | "Цэсда" ХХК | С.Эрдэнэцэцэг |
| Барилга бүтээц: | "Цэсда" ХХК | Ц.Бат-Очир |
| Халаалт, агаар сэлгэлт: | "Цэсда" ХХК | Д.Гантулга |
| Цэвэр бохир ус: | "Цэсда" ХХК | М.Эрдэнэцэцэг |
| Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж: | "Зураг төсөл консалтинг" ХХК | З.Бүжинлхам |
| Дотор холбоо, дохиолол | "Зураг төсөл консалтинг" ХХК | Ц.Баярбилэг |
| Барилгын төсөв: | "Зураг төсөл консалтинг" ХХК | Я.Тэрбиш |
| Инженер геологи: | "Ган хошуу" ХХК /Архив 06-2018-022/ | Дүгнэлт баталгаажсан |

Нэгтгэсэн дүгнэлт: /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/

Барилга байгууламжийн техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт;

Барилга, байгууламж баригдах газрын байгаль, цаг уурын ерөнхий өгөгдөл:
 Гадна агаарын температур -29.6°С
 Цасны ачаалал 30 кг/м²
 Салхины ачаалал 31 кг/м²
 Галд тэсвэрлэлтийн зэрэг II
 Барилгын галын ангилал 2
 Газар хөдлөлийн балл 8

Техник, технологи, дэд бүтцийн хангамж:
 Барилга баригдах талбайн инженер-геологийн судалгааны дүгнэлтийг "Ган хошуу" ХХК /06-2018-022/-д боловсруулсан ба газар хөдлөлийн 8 баллын бүсэд хамрагдаж байна.
 Суурь суух буурь хөрс нь бор шаргал, цайвар шаргал өнгөтэй, хатуу консистенцтэй, шавранцар чигжээстэй, бул чулуутай хайр хайрган ул хөрс бөгөөд уг хөрсний механик шинж чанарын үзүүлэлт нь:
 Барьцалдах хүч: Cⁿ=13 кПа

Дотоод үрэлтийн өнцөг: $\Phi^0=37.0^\circ$

Хэв гажилтын модуль: $E_0=45$ МПа

Тооцооны эсэргүүцэл: $R=350$ кПа

Барилга байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:

15 ортой эмнэлгийн барилга нь тэнхлэгээрээ 46.4 м х 16.8 м хэмжээтэй, ± 0.00 түвшнээс доош зоорьгүй, ± 0.00 түвшнээс дээш 2 давхар цутгамал төмөр бетон каркасан барилга, эмчийн байр, гарааш, моргтой байхаар төлөвлөгдсөн байна.

1-р давхарт: Гонх, хүлээн авах, эмнэлгийн даргын өрөө, эмийн сан, ажилчдын амралтын өрөө, эм хадгалах өрөө, чийрэгжүүлэх танхим, сургалтын танхим, холбооны өрөө, генераторын өрөө, дулааны узелийн өрөө, ариун цэврийн өрөө, нярав нягтлангийн өрөө, рентгений өрөө, үйлчлүүлэгч бэлдэх өрөө, цэвэр багаж хадгалах өрөө, ариутгалын өрөө, бохир багаж хүлээн авах өрөө, хог түр хадгалах өрөө, эмэгтэйчүүдийн үзлэгийн өрөө, эхо, шүдний эмчийн өрөө, тусгаарлах өрөө, үзлэгийн өрөө, эх баригчийн өрөө, вакцин хийх өрөө, шинжилгээ хүлээн авах өрөө, лаборатори, хүүхдийн эмчийн өрөө, хүлээн авах үзлэгийн өрөө, ариун цэврийн өрөөнүүд, шатыг,

2-р давхарт: Угаалгын өрөө, бохир хүлээн авах өрөө, цэвэр түгээх хадгалах өрөө, физик эмчилгээний өрөө, тарианы өрөө, сувилагчийн өрөө, 2 ортой хэвтэн эмчлүүлэх өрөө, ариун цэврийн өрөө, эрчимт эмчилгээний өрөө, мэс заслын өмнөх өрөө, ариутгасан багаж хадгалах өрөө, мэс заслын өрөө, боолтын өрөө, нярайн өрөө, төрөх өрөө, ариутгасан багаж хадгалах өрөө, төрөхийн өмнөх өрөө, төрсний дараах өрөө, 2 ортой хэвтэн эмчлүүлэх өрөө, эмч нарын хувцас солих өрөө, халуун цех, бэлтгэл, угаалга, агуулахын өрөө, шат зэргийг төлөвлөсөн байна.

Барилгын гол орцны хэсэгт "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчин шаардлагад нийцсэн зураг төсөл зохих дүрэм" /БД 31-112-11/-ийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж налуу зам төлөвлөсөн байна.

"Эмчийн байр, 2 машины гарааш"

Гонх, угаалгын өрөө, ариун цэврийн өрөө, зочны өрөө, гал тогоо, 2 машины гарааштай, өрөгт бүтээцэн барилга байхаар төлөвлөсөн байна.

"Морг"

Хонгил, цогцос хадгалах өрөө, цогцос бэлдэх өрөө, цогцос хүлээн авах өрөө, гаргах танхимтай, өрөгт бүтээцэн барилга байхаар төлөвлөсөн байна.

Барилгын гадна тохижилтод явган зам талбай, ногоон суулгамал, авто зогсоол төлөвлөсөн байна.

"15 ортой сум дундын эмнэлгийн барилга"

Барилгын үндсэн бүтээц нь:

Суурь: Цутгамал төмөр бетон баганан суурьтай, суурийн гадна талаар цутгамал төмөр бетон суурийн холбоос дамнуруутай,

Даацын үндсэн бүтээц: Цутгамал төмөр бетон араг бүтээцтэй,

Гадна хана: 360 мм зузаан хөнгөн бетон блокон хана, 150 мм зузаан хөөсөнцөр дулаалгатай, шавардлага өнгөлгөөтэй,

Хучилт: Цутгамал төмөр бетон хучилттай,

Дээвэр: Дулаалгатай, цутгамал төмөр бетон хавтгай дээвэртэй байна.

Халаалт, агаар сэлгэлт:

Халаалтын эх үүсвэр нь төвлөрсөн сүлжээнээс хангагдах ба бие даасан 1 системтэй 2 салаа шугамтай байна.

Барилгын өрөөний зориулалтаас хамааруулан агаар сэлгэлтийн ердийн болон механик сорох, агаар оруулах систем төлөвлөсөн байна.

Хашлага хийцийн дулаан дамжуулалтын коэффициент:

$K_{гх}=0.19 \text{ Вт/м}^2 \cdot \text{С}$, $K_{ху}=0.16 \text{ Вт/м}^2 \cdot \text{С}$, $K_{ц}=1.82 \text{ Вт/м}^2 \cdot \text{С}$,

$K_{гад \text{ хаал}}=1.82 \text{ Вт/м}^2 \cdot \text{С}$

Дулаан зөөгчийн температур: $70^{\circ}/90^{\circ}$

Дулааны нийт ачаалал:

$Q_{хал}=126.02 \text{ кВт}$

Цэвэр, бохир усыг төвийн шугамаас холбохоор зураг төслийг боловсруулсан байна.

Цэвэр, бохир усны тооцоо:

$q_{бүгд}=8.6 \text{ м}^3/\text{хон}$, $q_{хүй}=4.08 \text{ м}^3/\text{хон}$,

$q_{хал}=4.521 \text{ м}^3/\text{хон}$, $q_{бох}=8.6 \text{ м}^3/\text{хон}$

Галын усны систем төлөвлөсөн байна.

Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг:

Дэд өртөөнөөс барилга руу 400/230 В хүчдэлтэй TN-C-S (3 фаз + N) маягийн хамгаалалтын газардуулгын системийн 4 судал бүхий тэжээлийн кабель татаж, барилгын дотор сүлжээг TNS (5 утаст нойлын (N) ба хамгаалалтын нойлын (PE) дамжуулагчууд нь бүх системд тусдаа 3 фаз + N + PE) системээр гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Хэрэглэгчид цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааны I ба II дугаар зэрэгт орно.

Газардуулга, аянга хамгаалалтыг төлөвлөсөн байна.

Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу газардуулгын эсэргүүцэл 4 Ом-оос хэтрэхгүй байх шаардлагатай.

Сүлжээний хүчдэл 380/220 В байна.

Цахилгааны ачаалал:

Цахилгааны оролт:

"15 ортой сум дундын эмнэлэг"

$P_{т1}=126.0 \text{ кВт}$, $P_{т2}=120.0 \text{ кВт}$

$P_{с1}=164.0 \text{ кВт}$, $P_{с2}=157.0 \text{ кВт}$

"Эмчийн байр, гарааш"

$P_{c1}=24.8$ кВт, $P_{т2}=19.9$ кВт

"Моргын барилга"

$P_{c1}=21.7$ кВт, $P_{т2}=17.4$ кВт

Холбоо дохиолол:

Барилгын холбоо дохиоллын системд суурин телефон, галын дохиолол, хяналтын камерын систем, компьютерийн сүлжээ, кабелийн телевиз, зарлан мэдээлэх систем төлөвлөсөн байна.

Зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх;

Чиглэл тус бүрийн орон тооны бус экспертийн саналыг зураг төсөлд тусгасан байдал:

Барилга архитектур:

Эксперт нь барилгын ажлын зураг төслийг холбогдох норм ба дүрмийн шаардлагыг хангасан засвар өөрчлөлт хийсэн гэж дүгнэсэн.

Барилга бүтээц:

Экспертийн өгсөн үүрэг даалгаврын дагуу зураг төсөлд зарим засвар өөрчлөлтүүдийг хийсэн гэж дүгнэсэн.

Халаалт, агаар сэлгэлт:

Эксперт зураг төслийг холбогдох норм дүрмийг мөрдлөгө болгож боловсруулсан гэж дүгнэсэн.

Цэвэр бохир ус:

Эксперт цэвэр, бохир усны зураг төслийг холбогдох норм ба дүрмийг баримтлан боловсруулсан гэж дүгнэсэн байна.

Хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг:

Экспертийн гаргасан дүгнэлтээр техникийн шийдэл, тоног төхөөрөмжийн сонголт нь холбогдох норм ба дүрмийн шаардлагыг хангасан гэж дүгнэсэн байна.

Холбоо дохиолол:

Экспертийн гаргасан дүгнэлтээр холбоо дохиоллын зураг төсөл нь холбогдох норм ба дүрмийн шаардлагыг хангасан.

Төсөв:

Экспертийн гаргасан дүгнэлтийн дагуу төсөвт холбогдох засвар өөрчлөлтийг хийсэн гэж дүгнэсэн.

Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;

Хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан байдал:

Эмчийн байр, гарааш, морг, 15 ортой эмнэлгийн барилга баригдсанаар орон нутгийн иргэд эрүүл мэндийн үйлчилгээг цаг алдалгүй авах, хүчин чадал нэмэгдэх, эмч эмнэлгийн ажилчдын ажиллах орчин сайжрахын зэрэгцээ ажлын байр нэмэгдэх нөхцөл бүрдэх юм.

| | |
|----------------------|---|
| Төсөвт өртөг: | Эксперт нь: Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутаг дэвсгэрт баригдах "Эмчийн байр, гарааш, морг, 15 ортой эмнэлгийн барилга"-ын барилгын ажлын нийт төсөвт өртгийг 1 809 458 530.0 /нэг тэрбум найман зуун есөн сая дөрвөн зуун тавин найман мянга таван зуун гучин/ төгрөгөөр хянасан байна. |
|----------------------|---|

"Барилгын тухай" Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх", 39.5-д заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутаг дэвсгэрт баригдах "Эмчийн байр, гарааш, морг, 15 ортой эмнэлгийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөвт "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНБД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм"/БНБД 81-95-12/, "Барилгын материал, бүтээц эдлэлийн үнийн лавлах, түүнийг хэрэглэх заавар" /БД 81-109-14/, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны 12-р сарын 22-ны өдрийн 01/155 тоот албан бичиг, Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт XVII.1.49 -д 1800.0 сая төгрөгөөр батлагдсаныг үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэсэн дүгнэлт бичсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь экспертүүдийн хавсралт 11 хуудас дүгнэлтийн хамт хүчинтэй.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ
ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН**

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ

Ц.АМАРСАНАА

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


Б.ЭНХБОЛД

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.ХАНГАЛ


БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ
ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛТУЯА



[Handwritten signature]

[Handwritten signature]



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 66

Цагаан дэнж

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын шинэ суурьшлын бүсийн баршил тогтоосон газарт кадастр зураглалын дагуу Соёлын төвийн баруун талд байршилтай 0.1 га газрыг Эрүүл мэндийн төвийн зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх үүсч байгаа төрийн байгууллагын эзэмшил газрыг Улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг газрын даамал /Д.Номинчимэг/-т даалгасугай.

3. Эзэмшил газраа зориулалтын бус ашиглан, газрын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж, гэрээгээ жил бүр дүгнүүлж байхыг Эрүүл мэндийн төвийн дарга /С.Батням/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ТӨМӨРБААТАР

Захирамж 2018

7118122


ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 64020-00240
Хаяг: Эрдэнэцогт Цагаан дэнж 6-р баг


Огноо: 2018-10-30

Хашаны координат:

| Дугаар | X | Y | Өндөр | Урт | Цэгийг |
|--------|-------------|------------|-------|-------|--------|
| 1 | 5141909.007 | 639723.221 | 0.000 | 64.78 | 1-2 |
| 2 | 5141932.118 | 639783.734 | 0.000 | 60.82 | 2-3 |
| 3 | 5141877.114 | 639809.680 | 0.000 | 64.55 | 3-4 |
| 4 | 5141852.428 | 639750.036 | 0.000 | 62.61 | 4-5 |
| 5 | 5141909.007 | 639723.221 | 0.000 | 0.00 | 5-1 |



Талбарын хэмжээг 1:500 багцлаг мөрт
Зураг үйлдсэн: Д.Номинчимэг
(Эрх зүйч, гүйцэтгэл зөвшөөрөгч даалман)



Шалгасан: Ц.Төмөрбаатар
Эрх зүйч, гүйцэтгэл зөвшөөрөгч даалман

Зургийн масштабаг 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)
1:1000



БАЯНХОНГОР АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-20-15

2019-12-16 № 05-03-011/111

танай _____-ны № _____-т

Зураг төслийн тухай

ЦЭСДА ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цагаан дэнж 6 дугаар багт баригдах эмчийн байр гараж, моргийн барилгатай 15 ортой эмнэлгийн барилгын ажлын зурагт Монгол Улсын Эрүүл ахуй тухай хууль, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны А/164 тоот “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийж, дүгнэлт гаргах заавар” холбогдох стандарт, норм дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахаар 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ажлын зурагт эрүүл ахуйн хяналт хийлээ.

Нэг. Барилга байгууламжийн зориулалт:

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Цагаан дэнж 6 дугаар багт баригдах эмчийн байр гараж, моргийн барилгатай 15 ортой эмнэлгийн барилга. Барилгын зургийг “ЦЭСДА” ХХК гүйцэтгэсэн. Шифр: ЦЭ-12-12/2019,

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 66 дугаар захирамжтай, 1000 метр квадрат хэмжээтэй, эрүүл мэндийн төвийн зориулалтаар олгосон байна.

Уг барилга байгууламж нь ногоон байгууламж, авто машины зам талбайтай. Барилга нь тэнхлэгээрээ 41.6м*16.8м хэмжээтэй, 2 давхар, 15 ортой эмнэлгийн барилга, 15м*8м харьцаатай 2 машины гараж бүхий эмчийн байр, 9.6м*6м харьцаатай моргийн барилга байхаар төлөвлөсөн.

15 ортой эмнэлгийн барилга:

Нэгдүгээр давхарт: Хоёр хүлээн авах, үзлэгийн өрөө, ариун цэврийн өрөө, эмнэлгийн даргын өрөө, эмийн сан, эм хадгалах өрөө, амрах өрөө, чийрэгжүүлэх танхим, сургалтын танхим, холбооны өрөө, цахилгаан шитний өрөө, генераторын өрөө, дулааны узелийн өрөө, нярав, нягтлангийн өрөө, рентгений өрөө, рентгений удирдлагын өрөө, үйлчлүүлэгч бэлдэх өрөө, цэвэр багаж хадгалах өрөө, ариутгалын

өрөө, бохир багаж хүлээн авах өрөө, хог түр хадгалах агуулах, эмэгтэйчүүдийн үзлэгийн өрөө, ЭХО, шүдний эмчийн өрөө, тусгаарлах өрөө 1, тусгаарлах өрөө 2, эх баригчийн өрөө, үзлэгийн өрөө, вакцин үзлэгийн өрөө, вакцин хийх өрөө, вакцин хадгалах өрөө, эмчийн өрөө, шинжилгээн хүлээн авах өрөө, лаборатори, хүүхдийн эмчийн өрөө

Хоёрдугаар давхарт: ариун цэврийн өрөө, угаалгын өрөө /бохир, цэвэр хэсэг/, физик эмчилгээний өрөө, тарианы өрөө, сувилагчийн өрөө, 2 ортой хэвтэн эмчлүүлэгчийн өрөө 4, эрчимт эмчилгээний өрөө, эмчийн мэс заслын өмнөх өрөө, ариутгасан багаж хадгалах өрөө, мэс заслын өрөө, боолтын өрөө, төрөх өрөө, ариутгасан багаж хадгалах өрөө, төрөхийн өмнөх өрөө, төрсний дараах өрөө, эмч нарын хувцас солих өрөө, гал тогоо /халуун боловсруулалт/, бэлтгэл, угаалга, 2 агуулахын өрөө, ажилчдын хувцас солих өрөө

Ус хангамж, бохир ус зайлуулалтын байдал:

Цэвэр усны ашиглалтыг бие даасан систем байхаар төлөвлөсөн байна. Цэвэр усны гол түгээх шугам нь эрүүл ахуйн шаардлага хангасан цайрдсан ган хоолой байна.

Тус барилгын бохир ус нь өөрийн урсгалаар зайлуулагдаж төвийн бохир усны системд холбогдохоор төлөвлөсөн байна. Тус барилгад 40 м³ цооногийг төлөвлөсөн байна. Цэвэр ус, ариутгах татуургын ашиглалтын техникийн нөхцөлгүй байна. Хэрэглээний халуун усыг хурдны ус халаагчаар шийдвэрлэхээр тусгасан байна.

Дулаан хангамж, агаар сэлгэлтийн байдал:

Дулааны эх үүсвэр нь төвийн шугам байна. Дулааны шугам сүлжээг "Маралгүн" ХХК-ний техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэнэ. Барилгын халаалтын систем нь бие даасан нэг системтэй, 2 салаа шугамтай байна. Халаах хэрэгсэл нь ширмэн радиатор байна.

Агаар сэлгэлтийн системийг механик болон ердийн агаар сэлгэлтийн системтэй байхаар төлөвлөсөн байна. Мэс засал, төрөх өрөө, гал тогоонд гадна агаар оруулах болон агаар зайлуулах систем төлөвлөсөн байна.

Инженер геологийн судалгаа:

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын 6 дугаар багт баригдах Эрүүл мэндийн төвийн барилгын инженер геологийн судалгааны ажлыг "Ганхошуу" ХХК гүйцэтгэсэн байна.

Хоёр. Барилгын ажлын зураг төсөлд илэрсэн зөрчил, дутагдлууд:

1. Хуудас бүрт гарын үсэг зурж баталгаажуулаагүй,

Дүгнэх нь:

Барилга байгууламжийг зураг төслийн дагуу гүйцэтгэхэд эрүүл ахуйн талаас татгалзах зүйлгүй болно.

Хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрхийн хүрээнд:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх /Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана/, 14.2 дахь /Гомдлыг хүлээж авсан хяналт шалгалтын байгууллагын эрх баригч түүнийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх арга хэмжээ авна./

Хэрэв гомдол гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно/.

Хувийг: Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвд

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ Ц.УРАНГОО




ХҮЛЭЭН АВСАН:
ЦЭСДА ХХК-НИЙ ЗАХИРАЛ

Ц.ОРХОНТАМИР

ТАЙЛБАР.....

.....



БАТЛАВ
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЕРӨНХИЙ
АРХИТЕКТОР Д.С.ХҮРЭЛХУЯГ
2019.11.20 өдөр

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРДЭНЭЦОГТ СУМЫН “15 ОРТОЙ ЭМНЭЛГИЙН”
БАРИЛГЫН АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР**

2019-11-20

Дугаар: 48/2019 БХР

Баянхонгор хот

| 1 | 2 |
|---|---|
| 1. Барилга байгууламжийн байршил тогтоосон газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрын байршил, хэмжээ. | <ul style="list-style-type: none"> • Баянхонгор аймгийн Эрнэнэцогт сумын Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 06 өдрийн 66 дугаар захирамж. • 1000 квадрат метр газар |
| 2. Барилга байгууламжийн байршил, зориулалт, хүчин чадал. | <ul style="list-style-type: none"> • Баянхонгор аймаг Эрдэнэцогт сум Цагаан дэнж 6-р баг • Эрүүл мэндийн төвийн зориулалттай |
| 3. Барилгын хэмжээ. | <ul style="list-style-type: none"> • Тэнхлэгээрээ 41.6м х 16.8м харьцаатай эмнэлгийн барилга, 15м х 8м харьцаатай 2 машины гараж бүхий эмчийн байр, 9.6м х 6м харьцаатай моргийн барилга. |
| 4. Барилгын төрөл, давхрын тоо -дээд хязгаар -доод хязгаар | <ul style="list-style-type: none"> • 2 давхар • Зоорьгүй |
| 5. Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө | <ul style="list-style-type: none"> • Эрдэнэцогт сумын ерөнхий төлөвлөгөө |
| 6. Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл | <ul style="list-style-type: none"> • - |
| 7. Эдэлбэр газрын хэмжээ | <ul style="list-style-type: none"> • 1000 квадрат метр газар |
| Үүнээс: - Барилгажих талбай (70хувиас ихгүй) | <ul style="list-style-type: none"> • Нийт газрын 70 аас ихгүй %-д багтсан байх. |
| - Ногоон байгууламжийн талбай | <ul style="list-style-type: none"> • 30%-д тохижилт, ногоон байгууламж, тоглоомын талбай, авто зогсоол, авто зам. |
| - Авто зогсоол | - |
| - Бусад | - |
| 8. Барилгажилтийн улаан шугамын зай | <ul style="list-style-type: none"> • Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх. |
| 9. Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод, тавигдах шаардлага. | <ul style="list-style-type: none"> • Авто машины зогсоолыг хүрэлцээтэй байхаар төлөвлөж аль ойр төв замтай хатуу хучилттай замаар холбож төлөвлөх. • Явган хүний замыг MNS 6056 : 2009 стандартын шаардлагын дагуу төлөвлөх. • Ногоон байгууламж, цэцгийн мандал зэргийг тусгайлан төлөвлөж болно. |

| 1 | 2 |
|--|---|
| 10. Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага | <ul style="list-style-type: none"> • Гадаргын ус зайлуулалтыг тооцож төлөвлөх. |
| 11. Архитектур төлөвлөлтийн шаардлага. | <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрийн тоног төхөөрөмжтэй ажиллах орон зайг хүний аюулгүй ажиллагааг хангахаар төлөвлөх • Орчин үеийн стандарт шаардлагыг тусгах |
| 12. Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага. | <ul style="list-style-type: none"> • Дулаан хангамж техникийн нөхцөлийн дагуу • Холбоо техникийн нөхцөлийн дагуу • Цахилгаан техникийн нөхцөлийн дагуу • Цэвэр ус, ариутгах татуургыг бие дааж шийдэхээр төлөвлөж зураг, төсөвт заавал тусгах • Газар дээр инженерийн шугам сүлжээ шилжүүлэхээр төлөвлөсөн бол шилжүүлэх зардлыг төсөвт суулгаж өгөх |
| 13. Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл. | <ul style="list-style-type: none"> • Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх. |
| 14. Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ) | <ul style="list-style-type: none"> • Үерийн хамгаалалт, даланг зураг төсөвт тусгах |
| 15. Захиалагчийн нэр, хаяг, утас. | <ul style="list-style-type: none"> • Эрдэнэцогт сумын Эмнэлэг • Утас: |
| 16. Онцгой нөхцөл | <ul style="list-style-type: none"> • Газар хөдлөлийн 8 балл |

Анхааруулга:

1. Барилга барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.

2. Хуучин барилга, байгууламжийг зайлшгүй буулгах, зөөх, засварлах, шаардлагатай бол энэ тухай эрх бүхий байгууллагын албан ёсны техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг архитектур төлөвлөлтийн даалгаварт хавсаргах.

3. Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа АТД-т заасан нэр, зориулалт, барилгын давхрын тоо, хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд эскиз зураг батлагдахгүй болно.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ
Д Ү Г Н Э Л Т

Баянхонгор аймаг, Баянхонгор сум,
Номгон 1 дүгээр баг, Утас70443083
E-mail: bayankhongor@nema.gov.mn
http www.bayankhongor.nema.gov.mn

2019.12.18 № 18-04/03

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Баянхонгор аймаг Эрдэнэцогт сум
2. Зургийн шифр, зураг төслийн компани: ЦЭ-12-12/2019, "ЦЭСДА" ХХК
3. Барилга байгууламжийн зориулалт: Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн №123 тоот захирамж, моргийн барилгатай 15 ортой эмнэлэгийн барилга
4. Барилга байгууламжийн давхар, талбай, эзэлхүүн: зоорьтой 2 давхар, $S=1005.32\text{м}^2$ $V=5648\text{м}^3$
5. Галд тэсвэршилтийн зэрэг: төлөвлөсөн II
6. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф1.1
7. Зургийн иж бүрдэл: 6 хэсэг

Хоёр. Барилга байгууламжийн зураг
төслийн галын аюулгүй байдал

1. Барилгын давхаруудад гарц, "EXIT" тэмдэг, ослын гэрэлтүүлгийг төлөвлөх /БНБД 21-05-10 5.23, 6.25, 6.26/.
2. Гал унтраах (усаар хангах) ,гадна гидрант заавал байхаар тооцож, гидрантыг усаар хангах эх үүсвэрийг тогтоосон байх ёстой.
3. Гал тэсвэршилтийн I-III зэрэглэлийн барилгын гадна ханын гадаргууг шатдаг, тэсвэрлэн шатдаг материалаар дулаалахыг зөвшөөрөхгүй /БНБД 21-02-02-ийн 2.8/.Барилгад хэрэглэх дулаалгын хөөсөнцөр хавтан материалыг нормын дагуу шатдаггүй материал төлөвлөх. Материалын шинжилгээний дүгнэлтийг хавсаргах.
4. Аж ахуй нэгж байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг хүчин чадлыг тооцоолж нормын дагуу төлөвлөх./MNS 5566:2005/
5. Хот суурин төлөвлөлт барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм БНБД 30-01-04 Галаас хамгаалах шаардлага /заавал биелүүлэх 4 дүгээр хавсралт/ дагуу төлөвлөх.

6. Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл БНБД 24-04-05-ын хавсралт №14 дагуу гал түймэр илрүүлэх дохиоллын систем төлөвлөх. Мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх.

7. Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ MNS GOST R 12.2.143:2013-ын дагуу байрлуулах.

Гурав. Ерөнхий дүгнэлт

Дээрх шаардлагыг биелүүлснээр тус барилгын ажлын зураг нь галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа болно. /Ажлын зураг дээр зөвшилцөн засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаардлагатай/

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

| Зөвшөөрсөн сар, өдөр | Зөвшөөрлийн тэмдэг дарсан хуудасны дугаарууд | Нэмэлт тэмдэглэл |
|----------------------|---|--|
| 2019.12.03 | Нүүр хуудас, БА 4, 7, 33, ХАС 11, 12, 18, ХТ 10, ЦБУ 3, ХД 7,8,9,10 ЦБУ-3 | Барилгын ажлыг зураг төслийг дүгнэлтийн дагуу хийж гүйцэтгэх |

ДҮГНЭЛТ ГАРГАСАН
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ
АХЛАХ ДЭСЛЭГЧ *Х.ЦЭНД-ОЧИР*



БАТЛАВ : Холбооны газрын дарга... *С.Бурмаа* /С.БУРМАА/

ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

Дугаар 20190327/05...

Баянхонгор сум

2019/03/27

1. Барилгын байршил:

Баянхонгор аймаг Эрдэнэцогт сум Цагаандэнж 6-р баг

2. Техникийн даалгавар бичих болсон шалтгаан үндэслэл:

Баянхонгор аймаг Эрдэнэцогт сумын ЭМТ-ийн 2 давхар барилгыг интернет, телефон, кабелийн ТВ-ийн сүлжээгээр хангах болон кабелийн телевизийн оруулгыг оруулж монтажлах.

3. Техникийн үндсэн нөхцөл:

МХС ТӨК ийн техникийн нөхцөлийг үндэслэн мэргэжлийн байгууллагын удирдамж зааврын дагуу ашиглалтын шаардлага хангасан материалаар доорх ажлыг хийж гүйцэтгэх.

1. МХС ТӨК-ийн төгсгөлийн хуваарилах хайрцагнаас бүх өрөө рүү интернет, кабелийн телевиз, телефоны утаснуудыг сувагчлал болон хоолойгоор сүвлэж тараах.
2. Оффисын өрөө бүрт UTP кабелиар интернетийн холболт оруулах
3. Өрөө бүрт телефоны утас оруулга оруулах
4. Өрөөний хананд интернет, кабелийн телевиз, телефоны төгсгөлийн залгуурыг хөдөлгөөнгүй суулгах.
5. Монтаж холболтыг бүрэн хийж шалгасан байх.
6. Барилгын газардуулга хийж Ом-н эсэргүүцэл норм стандартад нийцэн хэмжилт хийсэн байна.

4. Шаардагдах материал:

1. П274 маркын телефоны утас
2. Дотор монтажны кабель / UTP/
3. Дотор монтажыг стандартын дагуу хийх
4. Давхар хоорондын монтажыг хийхдээ 100-н пластмасан хоолой ашиглан хийх
5. Интернет, телефон, кабелийн тв-ийн төгсгөвч байрлуулан шалгах

5. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай онцгой нөхцлүүд:

Шинээр баригдах барилгын интернэтийн гаднах оруулга дотоод монтаж, өрөө бүрийг интернэтэд холбох, телефонжуулах ажлын зардлыг төсөвт бүрэн тусгаж технологийн дагуу хийсэн байх шаардлагатай.

Энэхүү техникийн даалгаварыг гүйцэтгэхдээ Монгол улсын Харилцаа холбооны MNS 5471:2005,2016 стандартыг баримтална.

6. Ажлын гүйцэтгэлийн явцад мэргэжлийн заавар зөвлөгөө авч хамтарч ажиллах

7. Гүйцэтгэгчийн : Эрдэнэцогт сумын ЭМТ-ын дарга / С.Батням/

Холбоо барих утас: 80080228

Техникийн даалгавар боловсруулсан:

Ахлах инженер *Г.Вандансанги* /Г.Вандансанги /70444024, 88444190/

17

БАТЛАВ:
"МАРАЛГҮН" УУЗ
ЗАХИРАЛ: Э. ДЭЛГЭРЦОГТ



2019.04.15

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

1. Барилга объектийн нэр, хаяг: **Баянхонгор аймаг, Эрдэнэцогт сумын эрүүл мэндийн төвийн барилга**
2. Барилга объектийн байршил: **Баянхонгор аймаг Эрдэнэцогт сумын төв**
3. Дулааны хэрэгцээ бүгд : Гкал/цаг-аар:
 - а/ Халаалтанд :Гкал/цаг /150/
 - б/ Салхивчинд : Гкал/цаг
 - в/ Халуун ус : Гкал/цаг
 - г/ Технологи : Гкал/цаг
4. Дулаан хангамжийн систем**бие даасан**
5. **Одоо байгаа уурын зуухнаас урд талруу гарсан шугамнаас / Ф100 хос / Цэвэр усны Ф50 дан/ зэвэрдэггүй шугамаар анхны худаг гарган холболт хийж, хаалт арматурыг зохих нормын дагуу байрлуулна.**
6. Холбох цэгийн гидравлик үзүүлэлт
 - а/ Өгөх хоолойн даралт4-6...../ М.У.Б/
 - б/ Буцах хоолойн даралт4-5./М.У.Б/
 - с/ Шугамын статик түвшин
7. Дулааны эх үүсвэрийн температурын өгөгдөл :
 - а/ Өгөх ба буцах хоолойн температур гадна агаарын халаалтын үед
 - б/ Өгөх ба буцах шугамын температур гадна агаарын температур тооцооны үед
8. Хангагч байгууллагаас зураг төсвийн тооцоо, зураглалд тавих онцгой шаардлага **Барилгыг дулаан техникийн тооцоо хангасан дүүргэгч материалаар гадна ханыг хийх ба хаалга цонх, дээвэр зэрэг бусад хийцүүдээр дулаан алдагдал багатай байхаар төлөвлөнө. /Барилгад дулааны узелийг өрөө гаргаж, хэрэглэгчийн узель дээр манометр, термометр зэрэг хэмжих хэрэгслийг суурилуулна.**
9. Хангагч байгууллагаас барилга угсралтын ажилд тавих онцгой шаардлага : Барилгыг гадна шугам сүлжээг хийхдээ шалгарсан гүйцэтгэгч байгууллага нь техникийн нөхцөлийн төлбөр тооцоог хийж хангагч байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр барилга угсралтын ажилаа эхлүүлэх болно.

Техникийн нөхцөл олгосон :
Инженер: *Э.Мөнхдалай* Э.Мөнхдалай /88095794/

БАТЛАВ Б.БАЯРСАЙХАН
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ТӨХХК-ИЙН
БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ДАРГА



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар: А10/2019

2019-03-27-ны өдөр

Хүсэлт гаргагч байгууллага иргэний нэр: Эрдэнэцогт сум эрүүл мэндийн төв

Харилцах утас: 88856395 эмнэлгийн бичиг хэргийн ажилтан

1. **Байршил:** СЗДТГ-ын шинэ барилгын баруун талд
2. **Холбооны хэрэгцээ:** Холбооны шилэн кабель татах.
3. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу техникийн нөхцлийг МХС ТӨК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар кабель татах болон шилжүүлсэн тохиолдолд уг барилга байгууламж, объектыг техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.
4. **Техникийн үндсэн нөхцөл:** Эрүүл мэндийн төвийн барилгад кабель татах:
 - 4.1.1 Мэдээлэл холбооны сүлжээг СЗДТГ-ын шилэн кабелийн төгсгөлийн FDF-с шилэн кабелиар, телефон кабелийн хуваарилах хайрцагаас 10 хосын физик кабелиар татаж, шинэ барилгад хийгдэх кабелийн оруулгаар оруулж төгсгөлийн хуваарилах хайрцагт холбож цэнэглэнэ.
 - 4.1.2 Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.
- 4.2 **MNS 6668:2017** Холбооны худаг сувагчлалын байгууламжийн техникийн үзүүлэлт, суурилуулалтын шаардлага стандарт, **MNS 5207:2011** Шилэн кабелийн суурилуулалт, техникийн шаардлага стандарт, **MNS 6597:2016** Авто зам төмөр зам хөндлөн гарах болон гүүрэн байгууламжид холбооны кабель шугамыг суурилуулах ерөнхий шаардлага стандартыг мөрдөж ажиллана.
5. **Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай онцгой нөхцлүүд:**
 - 5.1 Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлага зааврыг баримтлан гүйцэтгэх.

6. Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:

- 6.1 Угсралтын ажил эхлэхээс 7 хоногийн өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эсэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ны Баянхонгор аймгийн газрын Шугам кабель тасгаар (Утас: 70440099,99062171) хянуулан баталгааг авсан байх.
- 6.2 Газар шорооны ажил гүйцэтгэхдээ харъяалагдах шугам кабелийн нэгжийн инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актанд хавсаргах.
- 6.3 Угсралтын ажил дууссаны дараа газрын мэдээллийн санд трассын зургийг оруулсан байх шаардлагатай бөгөөд оруулсан тодорхойлолтыг техникийн актны хамт хүлээлгэж өгнө.Тухайн газарт суурилуулагдсан холбооны багана сувагчлал болон шилэн кабелийг гадны механик гэмтлээс хамгаалах.
- 6.7 Уг сувагчлалыг цааш нь үргэлжлүүлэх болон шинээр кабель татах боломжийг хангах
7. **Техникийн нөхцөлийг:** Эрдэнэцогт сумын эрүүл мэндийн төвийн тоот албан бичгийг үндэслэн олгов.
8. Энэхүү техникийн нөхцөл нь зөвхөн МХС ТӨК-ийн кабелийн сувагчлал байгууламжийн хувьд гаргасан бөгөөд бусад компаниудын трасст тусад нь техникийн нөхцөл авна.

9. Шаардлагатай материал: а) шилэн кабель -100м
 б) 16 port switch-1ш
 в) Физик кабель 10 хос-100м
 г) Хуваарилах хайрцаг-1ш

Энэхүү техникийн нөхцөл нь олгогдсон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй.

Дээр заагдсан чиглэлүүдэд ажиллах тухай бүр МХС ХХК-н Баянхонгор газрын 95954401 утаст урьдчилан мэдэгдэж, хяналт хийлгэн ажиллах.

Техникийн нөхцөлийг
 хянасан:

Ерөнхий инженер

Ц.Одонтцья
 / Ц.Одонтцья/

Техникийн нөхцөлийг
 боловсруулсан:

ШК-н инженер

Б.Эрдэнэчимэг
 /Б.Эрдэнэчимэг/

20

БАТЦАВ
"БАЯНХОНГОР-ЭРЧИМ ХҮЧ" ЦТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.ОТГОНБААТАР

"БАЯНХОНГОР-ЭРЧИМ ХҮЧ" ЦАХИЛГААН ТҮГЭЭХ ХХК-ИАС
ОЛГОЖ БУЙ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2019 оны 04 дугаар сарын 24

№ 2019/33

Номгон

1. Объектийн нэр

Эрдэнэцогт сумын эрүүл мэндийн төвийн барилга

2. Байршил

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын төвд

3. Объектийн цахилгаан хэрэгслийн нийлбэр хүчин чадал, хэтийн ачаалал /кВт/

60 кВт

4. Тэжээлийг хаанахын ямар шугам сүлжээ, дэд станцаас авах

АТП-1 дэд станцын урд гаргалгаан дээр 2ширхэг төмөр бетон УКШ-9 маркын тулгуур нэмж босгож СИГ-35 дамжуулагч төгсгөлийн тулгуурт буулт хийж 380В цахилгаан авах. /шугамын трассыг Эрдэнэцогт сумын Эрчим хүчний монтеороор газар дээр нь тэмдэглүүлж авна./

5. Объект хүртэлх шугам, кабелийн урт, марк

Объект хүртэл 3*50+1*35 кабелаар тэжээх.

6. Салгаж залгах хэрэгсэл, автомат хамгаалалтууд, хэмжүүрийн хэрэгслийн шаардлага:

ЦЭХ хэрэглэх дүрмийн 7-ын 36-р заалтын дагуу тооцооны хэмжих хэрэгслийг хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг дээр тавина. Нэгдсэн шинэд 3 фазын 5А тоолуур, ачаалалд тохирсон гүйдлийн трансформаторыг сонгож тавина.

Газардуулга

Шит тоног төхөөрөмж газардуулж норм хэмжээнд нь бариулж, мэргэжлийн байгууллагаар хэмжүүлэх

8. Эзэмшлийн зааг

Тоолуур хэмжих хэрэгслийн боолтоор

9. Хэрэглээг тооцох цэг: Тоолуурын заалтаар

10. Тооцоо хийх хэлбэр: Дансаар /ХААН БАНК 5249044303 /

11. Нэмэлт шаардлага

- Кабель шугамын трасс, хамгаалалтын зурваст барилга барих, зам талбай засах, бетондохыг хориглоно.
- Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар цахилгаан техникийн байгууламжийн дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын дүрмийн дагуу гүйцэтгүүлэх. Хүчдэлийн түвшингийн +-5%-ийн хэлбэлзэлд зохицсон тоноглол суурилуулах.
- Гадна цахилгаан хангамжийн ил далд ажлын актыг бүрдүүлж 1%-г ашиглагч байгууллагад хүлээлгэн өгнө.

12. Техникийн нөхцөл авах тухай хэрэглэгчийн хүсэлт

Хэрэглэгчийн хүсэлт, тодруулах хуудсыг үндэслэн энэхүү техникийн нөхцөлийн дагуу 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Б.БАДАМЦЭЦЭГ

Хураамж 200 000 төгрөг

БАТЛАВ.
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА
...../Ц.ТӨМӨРБААТАР/

2018 оны 12 сарын 06 өдөр

БАТЛАВ.
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗУРАГ ТӨСЛИЙН "ЦЭСДА" ХХК –
ИЙН ЗАХИРАЛ

...../Ц.ОРХОНТАМИР/

2018 оны 12 сарын 06 өдөр

**ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ТАЛААР ЗАХИАЛАГЧ
ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭ**

Дугаар ЦЭ-12-4\18

2018 оны 12 сарын 06 өдөр

Баянхонгор хот

Нэг.Гэрээний ерөнхий нөхцөл

1. Монгол улсын иргэний, Барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу зураг төсөл боловсруулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах,харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний / цаашид гэрээ гэх/ зорилго оршино.
2. Энэхүү гэрээ нь зураг төсөл боловсруулах ажлын үнэ,чанар, гүйцэтгэх хугацааг эцэслэн тохирох үндэслэл болно.
3. Захиалагч байгууллага . **Баянхонгор аймгийн ХөОрХөБоТөлөвлөлтийн Хэлтэс**
4. Гүйцэтгэгч байгууллага:
Баянхонгор аймаг дахь **Зураг төсвийн "ЦЭСДА" ХХК**
5. 2018 оны 12 сарын 06-наас эхлэн 2019 оны 03 сарын 06 хүртэл 90 хоног дотор хийж гүйцэтгэхээр тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
6. Боловсруулах зураг төслийн нэр:
**Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын төвд баригдах
Эмчийн байр, Гараж, Моргтой "15 ортой эмнэлгийн" барилгын
ажлын зураг төсвийн үнэ -78 980 780 төг**

Хоёр. Захиалагчийн эрх , үүрэг

1. Зураг,төсөв зохиоход шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл, батлагдсан зургийн даалгавар, газар олголтын шийдвэр, инженерийн шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, газрын дэвсгэр зураг, геологи хайгуулын ажлын дүгнэлт технологийн бүдүүвч, тоног төхөөрөмжийн тодорхойлолт зэргийг бэлтгэн 2018 оны 12 сарын 08 ны өдөр гүйцэтгэгчид өгнө.
2. Зураг төсвийг зохиох,боловсруулах явцад өөрсдийн саналаар нэмэлт өөрчлөлт оруулах буюу гэрээний хугацааг өөрчлөх, гэрээг цуцлах шаардлага гарвал гүйцэтгэгчтэй хамтран энэ гэрээг дүгнэж,санхүүжилт хийж,асуудлаа эцэслэн шийдвэрлэнэ.
3. Гэрээг батлагдсанаас хойш ажлын 3 хоногийн дотор зураг, төсвийн ажлын тохиролцсон үнийн 50% хувьтай тэнцэх урьдчилгаа 39490390 төгрөгийг гүйцэтгэгчид төлнө. Зураг бүрэн дууссаны дараа үлдсэн 50%хувьтай тэнцэх 39490390 төгрөгийн төлбөрийг гүйцэтгэгчид олгоно.


4. Зураг төсөл зохиож дууссаны дараа түүний гэрээнд заасан иж бүрдлийг шалгаж энэ гэрээгээр тохиролцсон үнийг бүрэн төлж бэлэн болсон зураг төслөө актаар хүлээж авна.
5. Барилга угсралтын ажлын явцад зохиогчийн хяналтыг БНБД 11-04-09-ийн дагуу тусгай гэрээний үндсэн дээр хяналт хийлгэх тоо, зардлыг тохиролцоно.

Гурав: Гүйцэтгэгчийн эрх үүрэг

1. Зураг төслийн ажлын архитектур төлөвлөлт. Инженерийн болон техник, технологийн шийдлийг шинжлэх ухаан, техникийн дэвшилтэй уялдуулан өөрийн орны нөхцөлд тохируулан шийдвэрлэхийн хамт Монгол улсад дагаж мөрдөж буй зураг төслийн ажлын техникийн нөхцөл, эх орны стандарт, олон улсын жишиг, барилгын норм ба дүрмийн шаардлагыг хангасан байна.
2. Угсралтын бус зураг төслийн болон тооцооны алдаанаас зураг төсөлд засвар зөрчил гарвал яаралтай шийдвэрлэн үнэ төлбөргүй засч өгнө.
3. Захиалагчийн хүсэлтээр хоёр тал тохиролцсон нөхцөлд нэмэлт ажил / техник эдийн засгийн үзүүлэлт, тооцоо судалгаа, зургийн даалгавар боловсруулах, техникийн нөхцөл бүрдүүлэх, газрын зураглал, геологийн дүгнэлт гаргуулах / зэрэг үүрэг хүлээх болно.
4. Гэрээт ажлаа гүйцэтгэхээр туслан гүйцэтгэгч авах шаардлагатай бол энэхүү зааврыг үндэслэн түүнтэй гэрээ байгуулж ажиллах ба туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүнг гүйцэтгэгч захиалагчийн өмнө хариуцана.
5. Зураг төсөв бүрэн дууссаны дараа улсын магадлалд оруулах ажлыг бүрэн хариуцна.

Дөрөв: Захиалагч, гүйцэтгэгчийн харилцан хүлээх үүрэг

1. Зураг төсөл боловсруулах хийх ажлын үнийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж буй жишиг үнэ БД81-16-12-г үндэслэн **78 980 780** төгрөг байхаар тохиролцов.
2. Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэж чадаагүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд хэрэгжүүлээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар бодож буруутай талд алданги ноогдуулна.
3. Зураг төсөл боловсруулах нарийвчилсан графикайг шаардлагатай бол харилцан тохирч гэрээнд хавсаргана.
Энэхүү хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.
4. Талууд гэрээний биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
5. Энэхүү гэрээг 2018 оны 12 сарын 06ны өдөр 2% үйлдэж захиалагч гүйцэтгэгч тус бүр нэг хувийг хадгалав.
6. Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болж мөрдөгдөх ба гэрээнд нэмэлт өөрчлөлт хийвэл 2 тал тохироо хийж гарын үсэг тэмдэгээр баталгаажуулж үндсэн гэрээнд хавсаргана.

Захиалагчийг төлөөлж:
Эрдэнэцогт сумын
ЗДТГазрын дарга
...../Р.БОЛОРМАА /


Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

"ЦЭСДА" ХХК-ийн менежер
...../Ч.ЖАРГАЛДУЛАМ/
Хаан банк 5225278136